

**ANNEX K:
PASTURE SURVEY MANUAL
- MONGOLIAN VERSION -**

Final Report
The Study for Improvement Plan of
Livestock Farming System in Rural Area

March, 2006

Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг оношлох арга
Доор бичсэнийг сайтар уншиж танилцана уу.




А. Малчид бэлчээрийн хэмжилт хийхтэй холбогдсон харилцан хамтын ажиллагаа ба мэдээллийг хамтран эзэмших ажлын зохион байгуулалт.

1. Бэлчээрийн ургамлын өндөр (Ө) ба бүрхэц (Б)-ийн байдалд үндэслэн бэлчээрийн даацыг тооцоолно.
2. Өвөлжөө, хаваржааны бэлчээрт та бүхний хийсэн хэмжилтийн үр дүнг багийн дарга нар цуглуулан авч, ХАА-н түшмэлтэй хамтран нэгтгэж дүгнэнэ.
3. Цуглуулсан хэмжилтийн дүнг, өвлийг өнтэй давахын тулд ирэх өвөл бэлчээр ямар байдалтай байхыг урьдчилан тодорхойлох материал болгон ашиглах юм.
4. Сумын ЗДТГ дээр тооцоолж гаргасан бэлчээрийн даацын тооцоот хэмжээний нэгтгэсэн дүнг сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээн дэх өвлийн бэлчээрийн мэдээ болгож та бүхэнд урьдчилан хүргүүлэх төлөвлөгөөтэй байна.

Б. Хэмжилт хийх улирал ба газраа сонгох арга.

1. Өвс бүрэн ургалтандаа хүрэх үе болох 8-р сард жил бүр 1 удаа хэмжилтийг хийнэ.
2. Хэмжилт хийх газар нь та бүхний өвөлжөө, хаваржааны ойр орчим нутаг юм.
3. Гэхдээ өвөлжөө, хаваржааны хажууд биш.
4. Доорх зургийн 1-6-д үзүүлсэн ёсоор өвөлжөө ба хаваржаагаа төв болгон үүнээсээ 1км-ийн радиуст 3 газар, 2км-ийн радиуст 3 газар, нийт 6 газарт хэмжилт хийнэ. (Өвөлжөө, хаваржаанаасаа 1км зайтай 3 өөр газар, 2км зайтай мөн 3 өөр газарт)
5. Бэлчээрийн даацын тооцоот хэмжээ нь хэмжилтийн газраа хэрхэн сонгохоос хамаарах тул зурагт үзүүлсэнтэй адилаар тохиромжтой газрыг сонгон авахад онцгой анхаарна уу. Худгийн ойр орчин зэрэг үргэлжилсэн халцгай газарт хэмжилт хийхгүй.

Нийт: 6 газар
(6 газар \times 10 цэг = 60 цэг)




Сонгосон 6 газар тус бүрт 10 цэгт, өөрөөр хэлбэл нийт 60 цэг дээр хэмжилт хийнэ.

6. Нэг тойрог дээрх 3 газрын байршлыг хоорондоо өөр өөр газруудад байхаар сонгох хэрэгтэй.
7. Хэмжилтийн нэг газарт дөрвөлжин хүрээг тус бүр 10 удаа байгуулан хэмжилт хийнэ.
8. Иймд, энэхүү 10 удаагийн хэмжилтээ 6 газар тус бүр дээр хийх тул 1 малчин нийт 60 удаа дөрвөлжин хүрээ байгуулж хэмжилт хийнэ гэсэн үг юм.


В. Ургамлын өндөр ба бүрхэцийг тодорхойлох арга.

1. Юуны өмнө 1 метрийн 2 саваа мод ба 30см-ийн шугам, бичгийн хэрэгсэл, тэмдэглэл хийх цаас (нийт бш) зэргийг бэлдэнэ.
2. 2 саваа модныхоо нэгийг аль болох хол шидэж, буусан дурын газрыг хэмжилт хийх цэгээр сонгож авна.
3. Үлдсэн 1 саваагаа шидсэн саваандаа тэгш өнцгөөр байрлуулан тавина.
4. $1\text{м} \times 1\text{м}$ -ийн дөрвөлжин хүрээ үүсгэхийн тулд зурагт үзүүлсэнчлэн газарт дахин 2 туслах шугам татна.






5. Дөрвөлжин хүрээгээ үүсгээд түүн дотроосоо нийт 5 ургамлыг сонгож, өндрийг нь хэмжээд тэмдэглэл хөтлөх тусгай цаасан дээрээ тэмдэглэнэ.
6. Ургамлын өндрийг хэмжихдээ түүнийг гараараа сунгаж байгаад хэмжих бус өөрийнх нь харагдаж байгаа өндрийг хэмжинэ гэдгийг анхаарах хэрэгтэй.
7. Мөн, хүрээн дотор 2-оос дээш төрлийн ургамал ургасан байвал тэдгээрийн тус бүрийнх нь өндрийг хэмжих хэрэгтэй. Жишээлбэл хүрээн дотор таана, хялгана, бударгана 3 ургасан байвал тэр 3 төрлийг 3-ууланг нь хэмжих хэрэгтэй.
8. 30 см-ийн шугамнаас өндөр ургасан дэрс, харгана зэрэг ургамлын өндрийг хэмжихгүй. Гэхдээ 30см-ээс богино ургасан дэрс, харганыг хэмжинэ.
9. Дараа нь дөрвөлжин хүрээн (1м×1м) доторх ургамлан бүрхэц (нэгж талбайд ноогдох ургамлын эзлэх хувь)-ийг хэмжинэ. Үүнийг хэмжих арга нь доорх байдалтай байна.
10. Юуны өмнө дөрвөлжин хүрээг дараах зурагт үзүүлснээр 4 тэнцүү хэсэгт хувааж хэрээслэн зурна.



Хэрээс хэлбэрийн туслах шугам зурж, дөрвөлжин хүрээгээ 4 тэнцүү хэсэгт хуваана.

11. Дараа нь үүссэн 4 дөрвөлжингийнхөө нэгийг нь сонгож түүнийгээ дахин 4 хэсэгт хувааж зурна. (Доорх зургийг үзнэ үү)




Туслах шугам татаж 4 хуваасныхаа 1-ийг нь дахин туслах шугамаар бүр жижиг 4 хэсэгт хуваана.

12. Ингээд ургамлан бүрхэцийг хэмжих бэлтгэл хангагдлаа.
 13. 1м×1м-ийн хүрээг 100% гэж үзвэл түүн доторх 4 дөрвөлжин нэг нь 25% болно. 2-ыг нийлүүлбэл 50%, 3-ийг нийлүүлбэл 75% болно.
 14. Ингээд дөрвөлжин тус бүрийг сайтар ажиглаж, доторх ургамлыг нь нэг дор бөөгнүүлбэл уг талбайнхаа хэдэн хувь нь болохыг тогтоогоод үзнэ үү.
 15. Ойролцоогоор хэдэн хувь болохыг нь тогтоосныхоо дараа дараах хүснэгт дэх 5 ангиллыг тэмдэглэсэн 1-4 хүртэлх тоо, эсвэл + тэмдэгийг тэмдэглэлийнхээ цаасан дээр оруулж бичнэ үү.

Бүрхэц (5 ангилал ба тэдгээрийн хувь)

Ангиллууд	%
4	76~100%
3	51~75%
2	26~50%
1	6~25%
+	1~5%

16. Жишээлбэл, 25-50% байна гэж үзсэн бол 2 гэж бичнэ. Хэрвээ 50-75% байвал 3 гэж бичнэ.



1м×1м-ийн дөрвөлжин хүрээнд ургамлын бүрхсэн байдал хэдэн % бэ?

17. 25%-иас доош гэж үзсэн бол 1 боловч хэрвээ тэр нь 5%-иас бага байвал түрүүнд 4 тэнцүү дөрвөлжнийхөө нэгийг нь дахин 4 хувааж үүсгэсэн дөрвөлжнөөрөө баримжаалан + тэмдгийг цаасан дээрээ тэмдэглэнэ үү.
18. Ингээд нэг хүрээн доторх хэмжилт дууслаа.
19. 2-рт заасантай адилаар нэг саваагаа дахин хол шидэж дараагийн хүрээгээ үүсгээд хэмжилтээ үргэлжлүүлцгээе.
20. Хэмжилт хийх 1 газар тус бүрт 10 цэгт, өөрөөр хэлбэл 10 удаа дөрвөлжин хүрээ үүсгэж хэмжинэ.
21. 1 газрын хэмжилт дуусаад дараагийн газар луу явж, хэмжилтээ үргэлжлүүлцгээе.
22. Тэмдэглэл хөглөх цаас 6 ш нь 1 иж бүрдэл болно. 1 хэмжилтийн хэсэгт 1 цаасан дээр тэмдэглэл хийнэ. Бүх газруудад хэмжилт хийж дуусахад 6 цаас бүгд бөглөгдсөн байх ёстой.
23. Тэмдэглэлийн цаасан дээрээ тус тусын дөрвөлжин хүрээн дотор дийлэнхийг эзлэх 1-3 (илүү их ургасан байна гэж харагдах) ургамлын нэрийг тэмдэглэнэ үү.
24. Тэмдэглэл хөглөх жишээг доор үзүүлэв.

**ANNEX L:
TRADITIONAL WELL
CONSTRUCTION MANUAL
- MONGOLIAN VERSION -**

Final Report
The Study for Improvement Plan of
Livestock Farming System in Rural Area

March, 2006

ЖАЙКА

ГОВИЙН НӨХЦӨЛД ГАР ХУДАГ
ГАРГАХ ЗААВАР

2004, 6 дугаар сар

Зохиогч: Р. Оюунсүрэн
Н. Түмэн - Өлзий
Д. Мөнхгэрэл

Өмнөх үг

Ардын уламжлалт гар худгийг монголын нүүдэлчин малчид эрт дээр үеэс өөрсдийн хүчээр гарган ашиглаж ирсэн бөгөөд худаг байгуулах арга барил нь цаг үетэйгээ хамт өөрчлөгдөнө хөгжисөөр өнөөдөртэй золгожээ.

Тухайлбал урьд гар худгийг ялангуяа говийн нөхцөлд хөрсний нуралт үүсэхгүй, ундрагыг нь найдвартай гаргах талаас нь бодож ихэвчлэн өвлийн улиралд гаргадаг байсан бол сүүлийн үед хөдөлмөр хөнгөвчлөх болон ажиллах хүчний хүрэлцээ шаардлагын улмаас газар гэсэж, малчид харьцангуй зав чөлөөтэй болдог зун, намрын улиралд гаргах болжээ. Мөн уламжлалт гар худаг гаргахад түгээмэл хэрэглэдэг чулуу хайрга, шавраас гадна цемент, машин трактор, ус шавхах насос зэрэг орчин үеийн техник, материал хэрэгсэлийг өргөн хэрэглэдэг болж байна. Уст цэгийг тогтоохдоо газрын гадрага, өвс, ургамалын байдлыг шинжиж үздэг уламжлалт аргаас гадна сүүлийн үед цахилгаан хайгуулын аргыг ч хэрэглэх боллоо.

Ер нь малчид гар худаг гарган ашиглах сонирхол ихтэй байдаг тул тэдний хүсэлтээр уст цэгийн хайгуул, тандалтын ажил ч явагддаг. Гэвч малчид өөрсдөө уст цэгийг яг нарийн тогтоож чадахгүй, гүнзгий ухвал аюултай, элсэрхэг хөрс нурдаг, хүн хүч хөрөнгө мөнгө хүрэлцээгүй зэрэг олон янзын шалтгаанаас үүдэн гар худаг гаргах ажил бараг зогсонги байдалд орж, одоо ашиглаж буй цөөхөн хэдэн худаг нь бага гүнд гаргасанаас ундрага муутай байдаг байна.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын туршилтын судалгааны баг 2003 оны 9 сараас эхлэн Дорноговь аймагт худгийн хайгуул, судалгааны ажлыг хэрэгжүүлэх явцад хөдөөгийн малчдын аж амьдралд гар худаг ихээхэн ач холбогдолтой болохыг сайтар ойлгосон билээ. Ингээд гар худаг байгуулах ажилд бага ч гэсэн хувь нэмэр болох үүднээс уламжлалт гар худгийн мэргэжилтэн Р.Оюунсүрэн, Н.Түмэн-Өлзий нарын хамтын бүтээл болох энэхүү "Говийн нөхцөлд гар худаг гаргах заавар"ыг өргөн барьж байна. Таалан соёрхоно уу!


"Монгол Улсын хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах судалгааны төсөл"
Судалгааны багийн ахлагч Фужита Такаши

Гарчиг


Өмнөх үг	
Нэг. Гар худаг гаргах тухай	1
Хоёр. Гар худаг гаргахад бэлтгэл ажил	2
Гурав. Гар худаг гаргах газрыг сонгох	3
Дөрөв. Бэлтгэл ажил	4
Тав. Материал бэлдэлт	4
Зургаа. Гар худаг ухах, хаших	5
6.1 Худгийн диаметрийн сонголт	5
6.2 Худаг ухах зарчим	5
6.3 Уурхайн хэсгийг ухах, шороог гаргах	6
6.4 Уст үенд ухах, шороо усыг зайлуулах	6
6.5 Уст үеийг хаших	7
6.6 Уурхайн хэсгийн ханыг хаших	8
6.7 Худгийн ёроолыг тэгшилж хайрга асгах	8
6.8 Хашлага, ханын завсраар хайрга асгах	9
6.9 Шавар цоож хийх	9
6.10 Худагас ус шавхан цэвэршүүлэх	9
6.11 Худагт хүзүүвч хийх	10
6.12 Худагт таг хийх	10
6.13 Худагт дулаалга хийх	11
Долоо. Хөдөлмөр хөдөлмөр хамгаалал	11

НЭГ. Гар худаг гаргах тухай

1. Малчдын зохион байгуулалт
 - Худаг гаргуулах хүсэлтэй малчдын бүлгийг байгуулж, хугдгийн ашиглалтыг хариуцах хүнийг тогтоно.
 - Худаг гаргах ажлыг хариуцах хүнийг тогтоно.
2. Хугдгийн байршлыг шийдэх
 - Хугдгийн байршлыг шийдэж, боломжтой бол урьдчилан туршилтын журмаар ухаж усны гүнийг тогтоовол зүгээр.
3. Сумд хандаж өргөдөл гаргах
 - Хугдгийн ашиглалт хариуцсан хүн, худаг гаргах ажлыг хариуцах хүн болон хугдгийн тухай мэдээлэл зэргийг бэлэн болгож худаг ухахад шаардлагатай материал тоног төхөөрөмжийг ашиглах талаар сумд хандаж өргөдөл гаргана.
4. Материал тоног төхөөрөмжийн зардлыг гаргах
 - Хугдгийн хийцийг шийдэж, барихад шаардлагатай материалын тоо хэмжээг тодорхойлж, зардлыг тооцоолно.
5. Худаг ухах ажлын графикийг шийдэх
 - Худаг ухах ажлын графиканд зохицуулалт хийж, түрээсээр хэрэглэх машин тоног төхөөрөмж материалыг үр дүнтэй ашиглах тал дээр санаа тавина.
6. Сумын фондод хийх төлбөр
 - Материал тоног төхөөрөмжийг ашиглахаасаа өмнө тогтсон хэмжээний зардлыг сумын фондод төлнө.



ХОЁР. Гар худаг гаргах бэлтгэл ажил



1. Ажлын график болон ажил үүргийн хуваарилалтыг нягтлах
 - Ажил дуусах хүртэлх ажлын график болон ажил үүргийн хуваарилалтыг шалгаж нягтлах
2. Худаг гаргах газрыг цэвэрлэх
 - Ажилд садаа болох мод чулууг зайлуулах
3. Хоноглох байр, материал тоног төхөөрөмжийг хадгалах байрыг шийдэх
 - Ажил хийх газрын ойролцоо, хоноглох байр болон материал хадгалах байрыг бэлдэнэ. Цемент зэрэг материалыг бороо уснаас хамгаалах.
4. Материал тоног төхөөрөмжийн тээвэрлэлт болон тоо хэмжээг нягталж шалгах.
 - Сумын төвөөс материал тоног төхөөрөмжийг авч ажил хийж буй газар хүртэл тээвэрлэнэ. Сумын төвд ч мөн ажлын байран дээр авчирсны дараа ч мөн тоо хэмжээг шалгана.
5. Материал авах газрыг тодорхой болгох
 - Чулуу, хайрга, шавар, дэрс зэргийг хаанаас авахыг тодруулсан байна.
6. Шороо болон хаягдал усыг хаях газрыг тодорхой болгох
 - Худаг ухах явцад гарсан шороог аль болох хол аваачиж дагтаршуулна.
 - Худаг гаргахад ашигласан усыг худаг руу буцаж урсахааргүйгээр аль болох холхон нам дор газар хаяна.

ГУРАВ. Гар худаг гарах газрыг сонгох:

Шинээр гаргах худгийг өвөлжөө, хаваржаа, хашаа, саравчнаас нилээд зайтай газарт усны үерт автахааргүй, мал услахад тохиромжтой байхаар сонгон авна.

Ургаамлын шинж:

Ургамлын шинж Уст үеийн дээд гадаргууд юм уу эсвэл уст үеэс дээш нүх сүвээр хөөрч өгссөн чийглэг орчинд үндэс нь хүрч ургадаг ургамлуудыг заагуур ургамал гэж нэрлэж болох юм. Үүнд:

- Бургас, улиас, жигд, хошоон, зэгс, цахилдаг - 5м хүртэл гүнд орших усыг заана.
- Чингэл, сухай, дэрс, элсний шарилж, хөхөргөнө, хиаг, чихэр өвс, тэмээн харгана, бөрмөг, сондуул - 10м хүртэл гүнд орших усыг заана.
- өмхий өвс, хайлаас - 15м хүртэл гүнд орших усыг заана.

Ургамал намхан тачир сийрэг ургасан бол ус гүнд байгаагийн шинж бөгөөд нөгөө талаар эрдэсжилт их байж болно. Харин ургамал олноороо бөөгнөрөн ургасан, өнгө зүс сайтай бол ус ойрхон байгаагийн шинж юм.

Дээрхи нэр бүхий ургамлууд дангаараа биш, ядахдаа хосоороо юм уу гуравуулаа хам ургасан байвал устайг баталгаатай нотолж буй юм. Устай газрын ургамал эрт ногоорч намар орой болтол сөлтэй байна.

Гадаргын шинж

- Сайр, судаг, жалгын дагуу болон тэдгээрийн уулзварт, хонхор, хотгор газар, уул ба хендийн зааг орчмоор, сунаж тогтсон хамрын үзүүр зэрэг газруудад усжсан бүсийн дээд гадаргуу газрын гадаргууд ойр оршдог.
- Уулс, толгодын ар, хэц намын заагаас арай дээхнүүр худаг гаргах нь тохиромжтой. Элсэн дов, довцогт өдөр шөнийн температурын ялгаатай байдлаас шалтгаалан чийг бууж, хөрсний цэнгэг усыг бүрдүүлдэг тохиолдол говь, хээрийн нутагт олонтаа ажиглагдана. Ийм газар хармаг ургасан байдаг.
- Өвлийн цагт дэрс сондуулыг дайрч газар хагарсан байвал нилээд арвин их ус байгаагийн шинж юм. Гэхдээ хагарсан газрын ойр орчимд дэрс, сондуулын ургац муу байвал ус нь нилээд гүнд байгаагийн шинж юм.
- Тоонолжин хагарсан газрын хоёр хагарлын огтлолцох цэг дээр ухвал учдарга сайтай устайн шинж.
- Хуурай хээр тал нутагт нар мандсаны дараахан ялаа, шумуул бужигнаж байвал ус ойрхоны шинж.
- Газар тохой хиртэй ухаж шаазан аяга хөмөрч булаад маргааш нь үзэхэд шаасан аяганы дотор тал хөлөрч, усан дусал бөнжигнөж байвал устайн шинж гэдэг.

ДӨРӨВ. Бэлтгэл ажил:

1. Хүрз 4-6ш
2. Лоом 2ш
3. Жоотуу 2ш
4. Лантуу 1ш
5. Хөрөө /цүдгэр/ 1ш
6. Хөрөө /гар/ 1ш
6. Сүх 1ш
7. Усны гутал 2ш
8. Олс 40м
9. Шороо, ус татаж гаргах сав 3ш (10л)
10. Гадас 3ш
11. Хүрз, жотууны иш 3ш
12. Тавцан хийх банз 5ш
13. Олсон шат 1ш
14. Малгай (Дээлний зах давсан малгай) 3ш
15. Ховоо хийх элгэвч хаймар 1ш
16. Мал услах онгоц хийх тракторын дугуй 1ш
17. Бээлий 20ш
18. Цүүц 1ш
19. Ачлагын тэрэг 2ш
20. Трактор 1ш

ТАВ. Материал бэлдэлт :


Ус гарах нь баттай тогтоогдсон нөхцөлд материал бэлдэлтийн ажлыг уурхайг малтаж байх ажилтай зэрэгцүүлэн дор дурьдсан ажлыг хийсэн байна.

- Шүүр хийх хайрга 1 машин (3.8 м³)
 - Хадаас /100мм/ 2кг
 - Ам таглаа /банз/ 0.05x 0.15x 4.0 4ширхэг
 - Дүнз 0.15 x 0.15 x 4.0 8ширхэг
 - Ус шавхах төхөөрөмж /молтомпа/ 1ш
- 02л/с-ын хүчин чадалтай, цагт 0,5л бензин /А=76/ хэрэглэдэг, Honda маркийн
- Чулуу, худгийн хашлагын материалын тээвэр 5 машин
 - Дэрс, худгийн хашлагын материалын тээвэр 0.5машин
 - Цемент 6 шуудай
 - Шавхалтын бензин /А-76/ 10л

ЗУРГАА. Гар хугдгийг ухах, хаших.


6.1 Хугдгийн диаметрийн сонголт, гүн:

- Хугдгийн гүн 4м хүртэл бол ухах уурхайн диаметрийг 4м, хугдгийн гүн 5м-ээс дээш бол ухаж эхлэх диаметрийг 6м байхаар сонгох хэрэгтэй.




6.2 Худаг ухах зарчим.

- Худаг ухах ажиллагааг хөрсний байдалтай уялдуулан 2.0-3.0 метрээс багагүй голчтой алсаас шатлан ухах замаар гүйцэтгэнэ.
- Өвөл худаг ухахдаа аргал, хөрзөн, заг, чулуун нүүрс зэрэг удаан цогшиж асдаг түлшээр галлаж хоноод өдөр нь ухна. Ялангуяа хад чулутай газар өвөл ийнхүү гал түлэхэд чулуу хагарч бугардаг учраас ухахад бүрч дөхөм байдаг.




6.3 Уурхайн хэсгийг ухах, шороог гаргах

- Уурхайг 3м малтсаны дараа гүнд 2 хүн ажиллахаар бодож богино иштэй хүртэй хүн нь бэлдэж өгч, урт иштэй хүртэй хүн нь шороог гадагш гаргахаар бодож малтах хэрэгтэй.
- Гарсан шороог ухах буй худгаас 10-20метрийн зайд зөөж асгах шаардлагатай. Эс тэгвэл маш их шороо гардаг учраас ойр асгавал ухсан нүх рүү орох аюултай.




6.4 Уст үенд ухах, шороо, усыг зайлуулах

- Ус аль ундарч шүүрч байгаа тал руу нь 40-50см гүнзгийлж ухна. Уурхайн хэсгийн ханыг тэгшилж цилиндр хэлбэртэй болгоно.
- Уурхайг малтаж байхдаа ус илэрсэн гүнээс доошхи хэсгийг 1 едөрт багтааж ухахгүй бол ундарсан ус нь шенөдөө хөөрч уурхайн ханыг нурахад бэлэн болгоод шавхах үед нуралт үүсдэг тохиолдол ихэнхдээ таардаг учир ажлын зохион байгуулалт сайн хийх хэрэгтэй.
- Өглөө эрт усыг (молпомпоор) шавхаж уст үеийг ухах ажлыг эхэлнэ.




6.5 Уст үеийг хаших

- Чулуун хашлагыг дугуй, доод хэсэгтээ хүнхэр хийвэл зай ихтэй, эдэлгээ сайтай болно.
- Хашлаганд тогтоц сайтай, тэгш, бат бэх чулууг сонгож авна.
- Чулуун хашлагын ханын зузаан 30 см орчим байх нь тохиромжтой.
- Хүдгийн ус хүлээн авах хэсгийг чулуугаар хашихдаа хашлагын ханын завсраар дэрс буюу дэрсэн жийрэг хийдэг. Энэ нь чулууны ерлөгийн тогтоцонд сайнаар нөлөөлөхөөс гадна худагт орох усны шүүлтүүр болдог.
- Чулуунууд бие биедээ тээглэн дотогш сугаран унахааргүйгээр байрлуулахыг гол болгоно. Эл зорилгоор чулууны бүдүүн талыг хана руу харуулж өрдөг.
- Хана хаших чулууг урьдчилан бэлтгэж том жижигээр нь ялгана.
- Чулууг ерөхдөө 30 см-ын зузаантайгаар 2-оор нь зэрэгцүүлж ерөх бөгөөд дээд үеийг нь ерөхдөө доод давхарын 2 чулууны амсрыг дарах замаар газрын гадаргууг тэлширтэл хашина.
- Хүдгийн тулга тавих чулуунд бат бэх, ачаалал даах чадвартай, хавтгай хамгийн том чулууг сонгон авч хүдгийн ёроолд ундаргыг хаахааргүйгээр бүдүүн өргөн талыг хана руу харуулж, тойруулан өрнө. Түүний араар жижиг хайрга асгаж өгнө. / өрөх байдлыг зурагт үзүүлэв /




6.6 Уурхайн хэсгийн ханыг хаших

- Чулуунууд бие биедээ тээглэн дотогш сугаран унахааргүйгээр байрлуулахыг гол болгоно. Эл зорилгоор чулууны бүдүүн талыг хана руу харуулж өрдөг.




6.7 Худгийн ёроолыг тэгшилж хайрга асгах.

- Худгийг хашиж ёроолыг цэвэрлээд ёроолд нь 2-3 см голчтой беерөнхий хайргыг 20-30см зузаантайгаар асгана.



6.8 Хашлага, ханын завсраар хайрга асгах


- Ус хүлээн авах болон уурхайн хэсэгт хашлага ба ханын завсраар 3.5см голчтой хайргаар дүүргэж, ундаргыг хамгаалдаг.
- Уст үеэ хамгаалахын тулд уст үеийг хаших зуур хашлага ба ханын завсраар хайргыг асгаж болно.



2-3см-ын голчтой хайрга 20-30см-ын зузаантай асгана.

6.9 Шавар цоож хийх

- Худагт гадаргуун бохир усыг оруулахгүйн тулд уурхайн дээд тал ба амсрын доод хэсэгт худгийн хашлагын гадна талаар 70см зузаан, 1.0м хүртэл гүн шавар манаас хийнэ. Үүнийг шавар цоож гэж нэрлэдэг.




6, 10 Худаас ус шавхан цэвэршүүлэх

- Газрын аль нам дор хэсэг рүү нь урсгахаар бодож шавхсан усыг гадагшлуулна.
- Усан дотор 1.0 метрээс доошгүй ухааж худга хийвэл зохимжтой.


6.11 Худагт хүзүүвч хийх

- Худгийн амсрын хэсэг нь 70см хүртэл өндөр хүзүүвчтэй байна.
- Худагт элдэв зүйл унах, худгийн ус бохирдох явдлаас сэргийлж, худгаас ус татах тохиромжтой нөхцлийг бүрдүүлдэг.
- Хүзүүвчийг дүнээр хийнэ.




6.12 Худагт таг хийх

- Худаг модон тагтай байна.



6,13 Худагт дулаалга хийх

- Хүзүүвчийг тойруулан шороо, чулуу, хайргаар чигжиж, дулаалга хэлбэрээр ашигладаг.
- Худгийн хүзүүвчний доод ирмэгт хөндлөн банз тавьж түүн дээрээ эсгий тавьж худаг хөлдөхөөс сэргийлдэг.
- Тагны дотор талд эсгий хадаж өгвөл худгийн ус хөлдөхгүй.



ТАВ. Хөдөлмөр хамгаалал.

- Хамгаалалтын малгайтай ажиллаж сурах.
- Цувтай ажиллах
- Газрын дээр ажиллаж байгаа хүмүүс гүнд ажиллаж байгаа хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд шууд хамааралтай гэдгийг сайн ойлгож ажиллах
- Дээр ажиллаж байгаа хүмүүс уурхайн амсар орчимд ан цав, хагарал байгаа эсэхийг байнга анхаарч шалгаж байх.
- Шавхсан ус эргэж худагруугаа орохоос болгоомжилж хамгаалалт хийж уурхайн амсрын эргэн тойронд ус тогтоохооргүй цэвэрлэсэн байна.
- Ус ба шороо татах хэрэгслийн уяаг байнга шалгаж, бат бэх уяагаар уяж байх.
- Уурхайн гүнд ажиллаж байгаа хүмүүст худал дохио, зангаа өгөхийг хориглоно.
- Ус шавхах төхөөрөмж /помпа/ салхины доор байрлуулах бөгөөд худаг дотор юмуу, худгийн салхины дээр байрлуулахыг хориглоно.

**ANNEX M:
SAMPLE OF CONTRACT FORM
- MONGOLIAN VERSION -**

M.1	WELL USE CONTRACT
M.2	SAMPLE OF DECREE
M.3	SOUN WELL FUND RULE
M.4	CONTRACT OF LIVESTOCK FUND
M.5	LIVESTOCK FUND RULE
M.6	AGREEMENT SAMPLE: WOOL PROCESSING PROJECT
M.7	AGREEMENT SAMPLE: DAIRY PRODUCTS SHIPMENTS AND SALES PROJECT

Final Report
The Study for Improvement Plan of
Livestock Farming System in Rural Area

March, 2006

ГЭРЭЭ

.....сумын засаг даргын 200. .. оны-р сарынний өдрийн . . . дугаар захирамжийг үндэслэн өмчлөгчийг төлөөлөн сумын хөдөө аж ахуй /байгаль орчин, газар/ хариуцсан түшмэл. /нэр / ба эзэмшигчийг төлөөлөн /бүлгийн нэр / малчдын бүлгийн ахлагч. /нэр / нар худаг эзэмшүүлэх тухай доорх гэрээг байгуулав.

1. Малчдын бүлэг (ахлагч:) нь “Монгол улсын Хөдөөгийн Мал аж ахуйн Тогтолцоог Сайжруулах Төлөвлөгөөг Боловсруулах Судалгаа”-ны төслийн хүрээнд шинээр гаргах/ сэргээн засварлах худаг (худгийн нэр:)-ийн засвар үйлчилгээг Үйл Ажиллагааны Төлөвлөгөө (. . . . оны. . . . сарын. . . . өдөр)-ний дагуу хамтран гүйцэтгэхийг тохиров.

2. Дээрх шинээр гаргах/ сэргээн засварлах худгийг ашиглалтад оруулах эсэхийн эцсийн шийдвэрийг худаг гаргах ажил дуусч усны чанарын шинжилгээний үр дүн гарсаны дараа малчдын бүлэг, судалгааны баг ба сумын засаг дарга нарыг хэлэлцсэний үндсэн дээр шийднэ.

3. Гурван тал тохиролцсон тохиолдолд худаг ашиглалтын гэрээ байгуулна.

4. Худаг ашиглалтыг баталгаажуулсаны дараа малчдын бүлэг 1.500.000 төгрөгийг 5 жилийн дотор “Сумын худгийн сан”-д төлнө.

5. Насос, генератор болон худгийн бусад тоног төхөөрөмжийг суурилуулахын өмнө малчдын бэлэг төлбөрийн эхний хэсэг болох 150.000 төгрөгийг "Сумын худгийн сан"-д оруулж, "Малчдын бүлгийн худгийн сан"-г байгуулан сумын Засаг даргаар батлуулна.

..... сум

..... 2004

..... бүлгийн ахлагч,
..... сум

..... сумын засаг дарга,
Монгол улс

Байлцсан:

Такаши ФҮЖИТА
Японы Олон улсын
Хамтын Ажиллагааны Агентлаг /ЖАЙКА/-ийн
Судалгааны багийн ахлагч

M2. Sample of Decree

..... сумын Засаг даргын захирамж

Он сар өдөр

№

Газрын нэр

Худаг эзэмшүүлэх тухай

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг /ЖАЙКА/-ийн тусламжаар хэрэгжиж байгаа "Монгол улсын Хөдөөгийн Мал аж ахуйн Тогтолцоог Сайжруулах Төлөвлөгөөг Боловсруулах Судалгаа"-ны төслийн хүрээнд сэргээн засварласан худгийн удаан хугацааны тогтвортой ашиглалтыг хангах үүднээс тушаах нь:

Нэг

..... /газрын нэр / -д төслийн хүрээнд сэргээн засварласан худгийг. /бүлгийн ахлагчийн нэр / ахлагчтай. /бүлгийн нэр / малчдын бүлэгт 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр

Худгийг удаан хугацаанд тогтвортой ашиглах ажлыг бүлгийн бусад гишүүдтэй хамтран зохион байгуулах үүргийг малчдын бүлгийг ахлагч. /бүлгийн ахлагчийн нэр /-д даалгасугай.

Гурав

Энэхүү захирамжийг үндэслэн байгуулах худаг эзэмшүүлэх гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу худгийг зүй зохистой ашиглаж байгаа явцад хяналт тавьж ажиллахыг сумын хөдөө аж ахуйн бодлого хариуцсан түшмэл. /нэр /, байгаль орчны хяналтын улсын байцаагч. /нэр /, багийн Засаг дарга. /нэр/ нарт даалгасугай.

Тамга

Гарын үсэг

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМ

Сумын худгийн сангийн ашиглалтын журам

2004 оны 6 сар

Нэг. Нийтлэг үндэслэл

/Зорилго/

1 зүйл. Дорноговь аймгийн Эрдэнэ сум нь «Сумын худгийн сангийн ашиглалтын журам»-ыг боловсруулан мөрдөх бөгөөд энэ нь худаг гаргах болон сэргээн засварлах төсөлд хамрагдаж буй малчдын бүлгүүдээс нийлүүлэх хөрөнгийг ашиглан зарцуулсанаар цаашид сум орон нутагтаа худаг гаргах, худгийн тоног төхөөрөмжийг сэргээн засварлах ажлыг дэмжих зорилготой болно.

/Сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага, хүн/

2 зүйл. Тус сангийн үйл ажиллагааг сумын Засаг дарга төлөөлөн удирдах бөгөөд үйл ажиллагааны хэрэгжилтийг сумын Засаг даргын тэргүүлэх «Сумын худгийн сангийн удирдах зөвлөл» хариуцан явуулах болно. Хөрөнгө санхүүгийн удирдлага, ашиглалтын асуудлыг сумын ЗДТГ хариуцна.

/“Малчдын бүлэг”-ийн тодорхойлолт/

3 зүйл. “Малчдын бүлэг гэдэг нь Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Судалгааны баг эсвэл “Сумын худгийн сангийн удирдах зөвлөл”-д хандан малчдын бүлэг байгуулах тухай санал дэвшүүлсэн 3 ба түүнээс дээш тооны малчдын нэгдэл юм. Малчдын бүлгийн гишүүд нь худгийн ашиглалт, засвар үйлчилгээ болон энэхүү үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг хамтран гаргах, зээлийн хөрөнгийг буцаан төлөх тухайд адил тэнцүү үүрэг, хариуцлага хүлээнэ.

Хоёр. Үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага хяналт

/Хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагааны удирдлагыг итгэмжлэн хариуцуулах тухай/

4 зүйл. Сумын худгийн сангийн удирдах зөвлөл нь банк зэрэг гуравдагч этгээдэд сангийн хөрөнгө санхүүгийн үйл ажиллагааны удирдлагыг итгэмжлэн хариуцуулж болно.

1/ Хөрөнгө санхүүгийн үйл ажиллагааг итгэмжлэн хариуцагч байгууллага:

Байгууллагын нэр: Эрдэнэ суман дахь ХААН банк

Байгууллагын хаяг: Утас: 5426

2/ Хөрөнгө санхүүгийн үйл ажиллагааг итгэмжлэн хариуцагч байгууллагын явуулах үйл ажиллагаа:

Санд хуримтлагдах хөрөнгө мөнгөний хадгалалт хамгаалалтыг хариуцаж, сумын Засаг даргын зүгээс шаардлага тавьсан үед сангийн хөрөнгө санхүүгийн байдлын тухай мэдээлэл өгөхийн хамт, сумын Засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч хоёрын гарын үсэг зурж баталгаажуулсаны

дагуу төлбөр тооцооны гүйлгээ хийнэ.

/Сангийн ашиглалт, үйл ажиллагааны зорилго/

5 зүйл. Малчдын бүлэг нь доор дурьдсан үйл ажиллагаа явуулах сонирхолоо илэрхийлбэл Сумын худгийн сангийн удирдах зөвлөлийн зүгээс тухайн үйл ажиллагааны бодит нөхцөл байдлыг нь судлан, ач холбогдолтой гэж үзсэн тохиолдолд санал гаргасан үйл ажиллагааг зээлээр санхүүжүүлж болно.

1/ Сумын хэмжээнд ашиглах боломжгүй болсон гүний худгийн сэргээн засварлах ажлын судалгаа болон сэргээн засварлах ажил

2/ Сумын хэмжээнд гар худаг сэргээн засварлах, шинээр гаргах.

3/ Одоо ашиглагдаж буй худгийн насос, генератор зэрэг тоног төхөөрөмжийг засварлах, шинээр солих.

4/ Сумын худгийн сангийн удирдах зөвлөлийн зүгээс сум орон нутгийг худагжуулах, худгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг бодлогын хүрээнд ач холбогдолтой гэж үзсэн бусад үйл ажиллагаа.

5/ Багаж тоног төхөөрөмжийг хүссэн бүлэг болон хүмүүст тогтоосон тарифын дагуу түрээслүүлэн ашиглуулна.

Гурав. Хөрөнгийн эх үүсвэр

/Санд нийлүүлэх хөрөнгийн хэмжээ/

6 зүйл. 2003 – 2006 онуудад Дорноговь аймгийн Эрдэнэ суманд Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас явуулах туршилтын судалгааны ажлын хүрээнд шинээр байгуулах, сэргээн засварлах худгийг ашиглах малчны бүлгүүд худгийн санд доор дурьдсан хэмжээний хөрөнгийг нийлүүлнэ. Санд нийлүүлэх хөрөнгийн хэмжээг энэхүү төслийн хэрэгжилтийн хугацаанд Монгол улсын хэмжээнд худаг байгуулах ажилд малчдын зүгээс нийлүүлэх хөрөнгийн хэмжээ, хөрөнгө оруулах аргачиллыг нэгтгэн тогтоосон тохиолдолд түүнд нийцүүлэн тодорхойлно.

1/ Өрөмдмөл худаг: 1,500,000 төгрөг

2/ Уурхайн худаг: 1,000,000 төгрөг

/Санг бүрдүүлэх аргачлал/

7 зүйл. Сангийн хөрөнгийг доор дурьдсан аргачилалын дагуу бүрдүүлнэ.

1/ Санд хөрөнгө нийлүүлэх малчид 6-р зүйлд заасан хэмжээний төлбөрийг 5 жилийн хугацаанд хийж барагдуулна. Нэг жилд хийх төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо 6-р зүйлд заасан нийт төлбөрийн хэмжээг 5 жилд тэнцүү хувааж, өрөмдмөл худагийн хувьд 300,000 төгрөг, уурхайн худгийн хувьд 200,000 төгрөг байхаар тогтооно. Худгийн санд оруулах хөрөнгийг 5 жилээс богино хугацаанд төлөх ба хамрагдах малчдын бүлгийн бүх

гишүүд нь энэ төлөлтөнд оролцсон тохиолдолд урьдчилан төлөлтийг хүлээн зөвшөөрнө.

2/ Санд хөрөнгө нийлүүлэх малчны бүлэг нь Сумын худгийн сангийн нэмэлт дүрмийн 1-р зүйлд заасан аргачилалын дагуу 5 жилийн хугацаанд барагдуулах төлбөрийн графикийг бүлгийн гишүүн тус бүрээр гаргаж, сумын худгийн сангийн удирдах зөвлөлөөр батлуулна.

3/ Төлбөр хийх арга: жилд 2 удаа /төлбөр хийх эцсийн хугацаа: 7 сарын 1, 12 сарын 1/ бэлэн мөнгөөр хийнэ.

4/ Эхний төлбөрийг худгийн ажил эхлэхээс өмнө хийх бөгөөд төлбөрийн хэмжээ нь энэхүү журмын 6-р зүйлд заасан нэг жилийн төлбөрийн дүнгийн тэн хагастай тэнцүү буюу өрөмдмөл худгийн хувьд 150,000 төгрөг, уурхайн худгийн хувьд 100,000 төгрөг байна.

/Санд хийх төлбөр нь тогтоосон хэмжээнд хүрэхгүй байх, төлбөрийг хугацаанд нь болон огт хийхгүй байх/

8 зүйл. Санд хийх төлбөр нь тогтоосон хэмжээнд хүрэхгүй байх, огт төлбөр хийхгүй байх зэрэг тохиолдолд дараахь арга хэмжээг авна.

1/ Эхний ээлжийн төлбөрийг хийгээгүй тохиолдолд:

Тус журмын 7 зүйлийн 4-т заасан эхний ээлжийн төлбөрийг хийгээгүй тохиолдолд, худгийн насос генератор зэргийг суурилуулахгүй.

2/ Төлбөрийг хугацаанд нь хийгээгүй тохиолдолд:

Энэхүү журмын 7 дугаар зүйлийн 1-д заасан 5 жилийн хугацаанд төлбөрийг барагдуулж дуусаагүй тохиолдолд, төлөгдөөгүй үлдэгдэлд ХААН банкны хугацаагүй хадгаламжийн сарын хүү /2004 оны 4 сарын байдлаар 0.8% байгаа/ дээр 0.2 хувийн хүүг нэмэн тооцож алданги ноогдуулна.

Төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүйн улмаас үлдсэн төлбөрийн хэмжээнд хүү тооцох тохиолдолд сумын ЗДТГ болон малчдын бүлгүүд нийт төлбөрийн үлдэгдлийн дүнг жил бүр харилцан магадлаж, санамж бичиг үйлдэж явна.

3/ Төлбөр хийх санхүү мөнгөний бололцоогүй болох, төлбөрийн хариуцлагаас татгалзах тохиолдолд:

Нэг жилд буцаан төлсөн төлбөрийн хэмжээ нь 7 зүйлийн 1-д заасан жилийн төлбөрийн хэмжээний 2/3 /гуравны хоёр/ болох өрөмдлөгийн аргаар гаргасан худгийн хувьд 200,000 төгрөг, уурхайн аргаар гаргасан худгийн хувьд 133,000 төгрөгөөс бага байх, эсвэл 2 жил дараалан дээр заасан нэг жилийн төлбөрийн 2/3 /гуравны хоёр/-той тэнцэх хэмжээний төлбөр хийгдсэн тохиолдолд тухайн малчны бүлгийн худаг эзэмших эрх нь Сумын худгийн сангийн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндсэн дээр түтгэлзүүлэгдэх болно. Худаг эзэмших эрхээ алдах хүртэлх хугацаанд

тухайн малчдын бүлгээс санд төлсөн хөрөнгө мөнгө нь сангийн орлого болох ба буцаан төлөгдөхгүй. Тухайн худаг эзэмших эрх нь шинээр байгуулагдах малчдын бүлэгт шилжэх бөгөөд эрх нь түтгэлзүүлэгдсэн бүлгийн зүгээс санд төлөх үлдэгдэл төлбөрийг худгийн шинэ эзэмшигч малчдын бүлэг төлөх хариуцлага хүлээнэ.

/Санд оруулах төлбөрийн хэмжээг өөрчлөх/

9 зүйл. Сумын худгийн сангийн үйл ажиллагаа эхэлсэнээс хойш 5 жилийн дотор худаг барих болон худгийн тоног төхөөрөмжийг сэргээн засварлах зэрэг ажилд баримтлах заалт, малчдын бүлгээс нийлүүлэх хөрөнгийн хэмжээ, төлбөр хийх аргачлал зэргийг улсын хэмжээнд нэгтгэн тогтоох тохиолдолд доор дурьдсаны дагуу санд төлөх төлбөрийн хэмжээг өөрчилнө.

1/ Малчдын өөрсдөөсөө санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг улсаас нэгтгэн тогтоохдоо 7 зүйлд заасан хэмжээнээс бага байхаар тодорхойлсон тохиолдолд, тус төслийн хүрээнд санд төлөхөөр заасан мөнгөн хэмжээг улсаас тогтоосон хэмжээнд хүртэл буулгана. Хэрэв 7 зүйлд заасан мөнгөн төлбөрийг малчдын бүлгийн зүгээс бүрэн барагдуулсан байх тохиолдолд, зөрүү мөнгийг сангаас буцаан авч болно.

2/ Малчдын өөрсдөөсөө санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг улсаас нэгтгэн тогтоохдоо 7 зүйлд заасан хэмжээнээс дээгүүр заасан тохиолдолд, тус сангийн үйл ажиллагаанд тухайн шинээр тодорхойлсон үнэлгээ, заалтыг баримтлахгүй.

/Төслийн хүрээнд хамрагдаж буй малчдын бүлгийн гишүүн солигдох/

10 зүйл. Төслийн хүрээнд хамрагдаж буй малчдын бүлгийн гишүүн солигдох /шинээр гишүүн элсэх, гишүүн бүлгээс гарах/ тохиолдолд, сумын худгийн сангийн удирдах зөвлөлд мэдэгдэж, тус зөвлөлөөс зөвшөөрөл авах шаардлагатай.

Дөрөв. Сангаас зээл олгох

/Сангаас зээл олгох/

11 зүйл. Төсөлд хамрагдах малчдын бүлэг болон шинээр байгуулагдах малчдын бүлэг нь сум орон нутагтаа гүний болон гар худаг шинээр гаргах, сэргээн засварлах, худгийн насос генераторыг засах болон шинэчлэн солих зэрэг хүсэлтэй байх бөгөөд хөрөнгө санхүү нь дутагдалтай байгаа тохиолдолд, сумын худгийн сангийн удирдах зөвлөлийн зүгээс бодит байдлыг судлан, орон нутагт ач холбогдолтой үйл ажиллагаа гэж дүгнэсэн тохиолдолд, доор дурьдсан нөхцөлтэйгээр зээл олгож болно.

1/ Зээлийг гэрээ байгуулсаны үндсэн дээр олгоно.

2/ Зээлээр олгох санхүүжүүлэлтийн дээд хэмжээ: 500,000 төгрөг

3/ Зээлийн хүү: Сарын 2%

4/ Зээлдүүлэх хугацаа: 6 сараас – 1 жил

5/ Буцаан төлөх арга, хугацаа: Зээлийн гэрээнд заасан графикайн дагуу.

6/ Зээлийн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байх тохиолдолд авах арга хэмжээ: Хугацаандаа төлөгдөөгүй байгаа үлдэгдэл мөнгөнд сарын 1%-ийн алданги нэмж ногдуулна.

7/ Зээл олгох нөхцөлүүд:

• Зээл авах малчдын бүлгийн хувьд:

6/-1 Зээл авах хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл гаргах.

6/-2 Малчдын бүлэг нь төлөвлөж буй ажлын нийт төсвийн 50-с дээш хувийг өөрсдийн хөрөнгө мөнгөөр санхүүжүүлнэ.

6/-3 Гурваас дээш өрх нэгдсэн зохион байгуулалттай байна.

6/-4 Бүлгийн гишүүд нь өр зээл тавиагүй байх

6/-5 Бүлэг нь авсан зээлээ барагдуулах хөрөнгийн баталгаатай байна.

/Зээл олгохыг зогсоох/

12 зүйл. Сумын худгийн сангийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах сангийн хөрөнгө мөнгөний хамгийн бага үлдэгдэл нь банкны дансны доод үлдэгдэл болох 20,000 төгрөг, сангийн үйл ажиллагаанд зайлшгүй гарах урсгал зардал зэргийг оруулан тооцоход 100,000 төгрөг байх шаардлагатай. Төсөлд хамрагдах малчдын бүлгүүд санд нийлүүлэх мөнгөө хугацаанд нь төлөхгүй байх, төлөхөөс татгалзах гэх зэрэг шалтгааны улмаас сангийн мөнгөний доод үлдэгдэл энд заасан хэмжээнээс доош орох тохиолдолд зээл олгох үйл ажиллагааг зогсооно.

/Сумын худгийн сангийн ашиглалтын журамд өөрчлөлт оруулах/

13 зүйл. Сумын худгийн сангийн үйл ажиллагаанд энэхүү ашиглалтын журмыг мөрдөх явцад өөрчлөх шаардлагатай заалт, агуулгад сумын худгийн сангийн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө.

Сумын худгийн сангийн нэмэлт дүрэм

/Малчдын бүлгээс санд нийлүүлэх хөрөнгийн бүтэц/

1 зүйл. Малчдын бүлгийн гишүүдээс санд нийлүүлэх хөрөнгийн хэмжээг тухайн малчин бүрийн өмч болох малын тооноос хамааран тогтооно.

Бүх малын тоог дараахь харьцаагаар хонин толгойд шилжүүлэн тооцож гаргана.

Тэмээ: 12

Адуу: 8

Үхэр: 8

Хонь: 1

Ямаа: 1

Эхлээд нэг хонин толгой малд ноогдох төлбөрийн (Төгрөг) хэмжээг дараахь аргачилалаар бодож гаргана.

а) Өрөмдмөл худаг

$T = 1,500,000 / (\text{Хонин толгойд шилжүүлсэн малчдын бүлгийн нийт малын тоо})$

б) Уурхайн худаг

$T = 1,000,000 / (\text{Хонин толгойд шилжүүлсэн малчдын бүлгийн нийт малын тоо})$

Өмчилж буй малын тоо толгойноос хамааруулан малчин тус бүрт ноогдох төлбөрийн хэмжээг (М) дараахь томъёогоор тооцоолон гаргана.

$M = T \times (\text{Хонин толгойд шилжүүлсэн малчин тус бүрийн өмчилж буй малын тоо})$

(Загвар жишээ: Өрөмдмөл худаг)

Бүлгийн нийт малын тоо : 2000 толгой		Бүлгийн нийт малын тоо : 3000 толгой		Бүлгийн нийт малын тоо : 4000 толгой	
Малчны малын тоо : 100	7500 төг	Малчны малын тоо : 100	50000 төг	Малчны малын тоо : 100	37500 төг
Малчны малын тоо : 200	150000 төг	Малчны малын тоо : 200	100000 төг	Малчны малын тоо : 200	75000 төг
Малчны малын тоо : 300	225000 төг	Малчны малын тоо : 300	150000 төг	Малчны малын тоо : 300	112500 төг

2004 оны..... сарын..... өдөр

Дорноговь аймгийн
Эрдэнэ сум Улаан уул баг

Мал зээлээр олгох гэрээ

Эрдэнэ сумын 3 - р багийн засаг дарга - ны тодорхойлолтыг үндэслэн багийн иргэдийн нийтийн хурал болон сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн санал нэгтэй зөвшөөрсөн тус сумын багийн малчин - нд нийт..... толгой буюу төгрөгийн малыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээлээр олгож, энэхүү зээлийн гэрээг байгуулав. Энэхүү зээлийн гэрээ нь 2004 оны сарын - наас эхлэн жилийн хугацаанд хүчинтэй байна.

Хуц :	_____	толгой,	(_____	төгрөг)
Эр хонь :	_____	толгой,	(_____	төгрөг)
Эм хонь :	_____	толгой,	(_____	төгрөг)
Ухна :	_____	толгой,	(_____	төгрөг)
Эр ямаа :	_____	толгой,	(_____	төгрөг)
Эм ямаа :	_____	толгой,	(_____	төгрөг)
Үнээ :	_____	толгой,	(_____	төгрөг)
Ингэ :	_____	толгой,	(_____	төгрөг)

Нийт малын тоо : _____ толгой, (_____ төгрөг)

Нэг. Үндэслэл

Цөөн малтай малчдын амьдралыг сайжруулах зорилгоор Эрдэнэ суманд " Малжуулах сан" төслийг хэрэгжүүлж байна. Амьдрал нь доройтсоноос "Малжуулах сан"-гийн төсөлд хамрагдахыг хүссэн малчид тус суманд олон байдаг тул Малжуулах санг зүй зохистой ашиглан, ядуу малчидад үр шимийг нь хүртээх нь чухал юм.

Зээлд хамрагдсан малчин малаа зохих ёсоор маллан өсгөж, гэрээнд заасан хугацаанд нь буцаан төлөх нь энэхүү 2 талт гэрээний үндсэн нөхцөл болно.

Хоёр. Малчны хүлээх үүрэг хариуцлага

1. Сумтай байгуулсан гэрээний заалтыг биелүүлж, зээлсэн малаа хувиарын дагуу хугацаанд нь буцаан төлнө. Батлан даагчтай байна. Батлан даагч нь зээл авсан малчинтай холбоотой бүх талын хариуцлагыг хүлээнэ.

2. Анх авсан малтай адил малаар эргүүлэн төлөхийг үндсэн зарчим болгох боловч онцгой тохиолдолд зээл авсан үеийн малын үнэлгээг жишиг болгон бэлэн мөнгөөр төлж болно. Бэлэн мөнгөөр төлөх тохиолдолд буцаан ёстой байсан малын зах зээлийн үнийн харгалзэн үзнэ.

3. Сүргийн дотор цус ойртохоос сэргийлэх, сайн үүлдрийн малын тоо толгойг олшруулах зорилгоор зээлээр олгодсон хуцыг нэг сүрэгт 2 жилийн хугацаагаар байлгаж, 2 жилийн дараа дараагийн зээлдэгч малчинд хүлээлгэн өгнө. Дараагийн ээлжинд зээлд хамрагдах малчин байхгүй тохиолдолд суманд хүлээлгэж өгнө.

4. Зээлээр авсан малыг эхний 2 жилийн хугацаанд амьдрал ахуйн хэрэгцээнд хэрэглэж болохгүй.
5. Зээлээр авсан сайн үүлдрийн малаас гарсан хээлтүүлэгчээс бусад малыг зарж болохгүй.
6. Малчид нь зээлээр авсан малаа өөрсдөө хариуцаж даатгалд хамруулна.
7. Гэрээнд заасан хугацаанд зээлээ буцаан төлөөгүй тохиолдолд торгууль хүлээж, зээлсэн мал болон хувийн эзэмшилд буй малаараа төлөх хариуцлагыг хүлээнэ.
8. Сумын талаас төсөл хариуцагчтай тухайн жилийн зээлийн төлбөрийн хувиарь, төлбөр хийх хугацаа, газрын тухай нарийвчлан тохиролцож, зээлээ буцаан төлөх талаар хариуцлага хүлээнэ. Зээлийг өөрийн биеээр буцаан төлнө.

Гурав. Сумын хүлээх үүрэг хариуцлага

1. Сум нь худалдан авах малд тавигдах нөхцөл, шаардлагуудыг үндэслэн нийлүүлэгчидтэй хэлэлцээр хийн, чанарын шаардлага хангасан малыг худалдан авч нийлүүлнэ.
2. Сум нь буцаан төлөгдсөн малд үнэлгээ хийж, арчилгаа маллагааг нь хариуцна.
3. Төсөлд хамрагдаж буй малчдад заавар, зөвлөлгөө өгч, тогтмол хугацаанд хяналт шалгалтыг хийнэ.
4. Зээлийн буцаан төлөх хугацаа хэтэрсэн өдөр бүрт тухайн жил буцаан төлөх малын үнийн дүнгийн 0.1% -иар бодож торгууль ноогдуулна.
Сум нь зээлийн торгуулийг зээлээр олгогдсон мал, малчны хувийн мал болон батлан даагчийн малаар төлүүлэх эрхийг эдлэнэ.
5. Ямар нэгэн шалтгаанаар буцаан төлөлт зогссон тохиолдолд үлдсэн бүх малыг эргүүлэн татна.

Дөрөв. Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаа

1. Энэхүү гэрээ нь малыг зээлдэгчид хүлээлгэн өгч, гэрээ байгуулсан өдрөөс эхлэн гэрээнд заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.
2. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.

Тав. Бусад

1. Гэрээ байгуулагч талууд нь төслийн хэрэгжилтийн байдлыг жилд нэг удаа шалгаж, үнэлэлт өгөн, үр дүнг нь тэмдэглэн үлдээнэ.
2. Гэрээний заалт биелэгдээгүй тохиолдолд буруутай тал хариуцлага хүлээнэ.

Гэрээ байгуулагч талууд:

Эрдэнэ сум:

Малчин:

Сумын дарга: Батлан даагч:

Хавсралт - 1

Эрдэнэ сумын [redacted] багийн малчин [redacted]-д
хүлээлгэн өгсөн малын төрөл, тоо толгойн жагсаалт

2004 оны сарынөдөр

Нэр :

	Малын төрөл	Үнэ	Төрөл	Өнгө зүс	Дугаар	Амьдын жин	Нас	Авсан газар
1	Хуц							
2	Хонь (эр)							
3	Хонь (эм)							
4	Ухна							
5	Ямаа (эр)							
6	Ямаа (эм)							
7	Үхэр (эм)							
8	Ингэ							

Хавсралт - 2

Эрдэнэ сумын [redacted] багийн малчин [redacted]-ны
зээлийн буцаан төлөлтийн график

2004 оны сарын ... өдөр

Боловсруулсан : ХАА хариуцсан түшмэл [redacted]

Нягтлан бодогч: [redacted]

Зөвшөөрсөн : Малчин [redacted]

#	Он		Малын төрөл	2005	2006	2007	2008	2009	2010
	Зүйл								
1	Мал	Хуц							
		Хонь (эр)							
		Хонь (эм)							
		Ухна							
		Ямаа (эр)							
		Ямаа (эм)							
		Үхэр (эм)							
		Ингэ							
2	Мөнгөн дүнгээр								

ЭРДЭНЭ СУМ

Малжуулах сангийн ашиглалтын журам

2004 оны 5 сар

Нэг. Нийтлэг үндэслэл

/Зорилго/

1 зүйл. Эрдэнэ сум нь «Малжуулах сангийн ашиглалтын журам» -ыг баталсанаар ЖАЙКА-ийн төслийн хүрээнд байгуулагдах «Малжуулах сан»-гийн санхүүжүүлэлтийг үр ашигтай ашиглан, зуд болон бусад байгалийн гамшигийн улмаас ихэнх малаа алдаж, цаашид мал аж ахуйгаа бүрэн хэмжээнд авч явахад бэрхшээлтэй байдалд орсон малчдад тусламж үзүүлэх болно. Энэ нь малчдын ахуй амьдралыг дээшлүүлж, улмаар нийт сумын цаашдын хөгжил дэвшилд эерэг нөлөө үзүүлэх зорилготой үйл ажиллагаа юм.

/Сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага, хүн/

2 зүйл. Тус сангийн үйл ажиллагааг Эрдэнэ сумын Засаг дарга төлөөлөн удирдах бөгөөд, төслийн хэрэгжилтийн ажлыг сумын ХАА-г хариуцсан түшмэл, сангийн хөрөнгө мөнгөний асуудлыг сумын төсөв хариуцсан мэргэжилтэн нар тус тус хариуцаж ажиллана.

Хоёр. Үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага хяналт

/Санхүү мөнгөний удирдлага/

3 зүйл. Сумын зүгээс сумын төвд үйл ажиллагаа явуулах ХААН банкинд «Малжуулах сан»-гийн данс нээнэ.

/Сумын зүгээс хүлээх үүрэг, хариуцлага/

4 зүйл. Сум нь дараахь үүрэг, хариуцлагыг хүлээн ажиллана. Үүнд:

- 1/ Сумын Засаг дарга нь жилд нэгээс доошгүй удаа буюу малчдаас хүсэлт тавьсан тохиолдол бүрийд сангийн ашиглалт, үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд танилцуулж байна.
- 2/ Төсөлд хамрагдах малчдыг дэмжих малчдын бүлгүүдийг сонгон тодорхойлох.
- 3/ Малчдад нийлүүлэх малыг худалдан авах болон хуваарилах ажлыг хариуцна.
- 4/ Малаар буцаан төлөлт хийгдсэн үед үнэлгээ хийх, малын арчиллагаа маллагааг хариуцах.
- 5/ Төсөлд хамрагдсан малчдыг зөвлөгөө, удирдамжаар тогтмол хангаж байхын зэрэгцээ, дэмжлэг үзүүлэх малчдын бүлгээр дамжуулан мэргэжлийн зөвлөгөө, удирдамж өгнө.
- 6/ Малыг буцаан төлөлтийн явцад хяналт, мониторинг хийх.

/Хяналт шалгалт/

5 зүйл. Эрдэнэ сумын ИТХ-ын зүгээс жилд нэгээс доошгүй удаа сангийн үйл

ажиллагаа, хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалтанд шалгалт хийнэ.

/Сангийн хөрөнгийг ашиглах хүрээ/

6 зүйл. Сангийн хөрөнгийг доор дурьдсан зорилгоор ашиглаж болно. Үүнд:

1/ Малын зээл.

Хувийн мал аж ахуйгаа цаашид бүрэн хэмжээнд авч явах бололцоогүй болсон бөгөөд сүргийн баланс алдагдаж, «гачигдлын тойрогт» ороод байгаа малчдад дутагдаж буй тоо толгойн хэмжээгээр малыг зээлээр олгож, улмаар мал аж ахуйгаа бие даан авч явах бололцоотой түвшинд хүргэх.

2/ Сайн чанарын малын фонд бий болгох зорилгоор үйлдэр сайтай мал оруулж ирэх, малчдад түрээсээр олгох.

Сум нь сайн үйлдрийн мал худалдан авчирч, хүсэлт тавьсан малчдад түрээслүүлэх журмаар сумын нийт малын фондын чанарыг дээшлүүлэх.

3/ Бусад.

Сумын засаг даргын зүгээс «Малжуулах сан»-гийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг санал болгож болно.

Гурав. Сангийн ашиглалт

/Малжуулах санд бүрдүүлэх хөрөнгө/

7 зүйл. Эрдэнэ сумын зүгээс «Малжуулах сан»-гаас хөрөнгө оруулалт хийх нөхцөлд тохирох 6 малчин өрхийг санал болгосон бөгөөд ЖАЙКА байгууллагын зүгээс сумын дэвшүүлсэн саналыг дэмжсэн тул доор дурьдсан толгой малаар тооцоолон 2004 оны 6 сарын өдөр нийт: төгрөгийн санхүүжүүлэлтийг хийсэн болно. Энэхүү санхүүжүүлэлт нь тус санг бүрдүүлэх хөрөнгө болно.

1/ Тэмээ:

..... толгой, төгрөг

2/ Адуу:

..... толгой, төгрөг

3/ Үхэр:

..... толгой, төгрөг

4/ Хонь:

..... толгой, төгрөг

5/ Ямаа:

..... толгой, төгрөг

/Малжуулах сангийн ашиглалтын хүү болон санхүүжүүлэлтийг буцааж төлөх арга/

8 зүйл. «Малжуулах сан»-гийн ашиглалтын зээлийн хүү нь жилд 3% байна. Сум орон нутагтаа цаашид сайн чанарын шилмэл мал өсгөн үржүүлэх тус сангийн зорилтын дагуу, буцаан төлөлтийг хөрөнгө оруулалт авсан үеийн малтай ижил төрлийн малаар авах явдлыг суурь заалт болгон хэрэгжүүлнэ.

Авсан үеийнхтэй ижил малаар буцаан төлөлт хийх бололцоогүй тохиолдолд, сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч талын зөвшөөрсөний үндсэн дээр буцаан төлөлтийг малын төрөл үнэ ханшаар тооцоолон бэлэн мөнгөөр хийхийг зөвшөөрнө. Буцаан төлөлтийг хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд, хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алдангийг тухайн малчинд ноогдуулах болно.

/Сангийн үйл ажиллагаанд хамрагдах малчин/

9 зүйл. Сангийн үйл ажиллагаанд хамрагдах малчдыг сонгох тухай.

1/ Малжуулах сангийн үйл ажиллагаанд дараах нөхцөл байдалтай малчдыг хамруулж болно. Үүнд:

- Тодорхой жилийн хугацаанд мал малласан туршлагатай байх
- Өөрийн гэсэн өвөлжөө, хаваржаатай болон мал услах худаг устай байх шаардлагатай
- Ажиллах хүн хүчтэй байх
- Банк болон бусдад өр зээлгүй байх
- Хариуцлага өндөртэй байх

Эдгээр нь суурь нөхцөлүүд болох бөгөөд сум нь дотроо нэмэлт нөхцөл тодорхойлж болно.

2/ Малжуулах сангийн үйл ажиллагаанд хамрагдах малчид нь багийн засаг даргын зөвлөмжийн дагуу, сумын засаг даргын зөвшөөрөл авна.

3/ Малжуулах сангийн үйл ажиллагаанд хамрагдах малчид нь батлан даагчидтай байх шаардлагатай бөгөөд малчин нь зээлсэн малаа буцаан төлөх боломжгүй болсон тохиолдолд батлан даагч нь хөрөнгө мөнгөний буцаан төлөлтийг хариуцна.

/Хөрөнгө оруулалтаар ирэх малын төрөл, тоо толгой/

10 зүйл. Сангийн хөрөнгө оруулалтаар авах малын тоо толгой нь бод, бог нийлээд нийт 100 толгой байна. Сангийн үйл ажиллагаанд оролцох сонирхолтой малчид нь өөрсдийн маллаж байсан мал сүргийн тоо толгойн мэдээллийг төрөл тус бүрээр нь, түүнчлэн зээлээр авах сонирхолтой байгаа мал сүргийн бүтцийг малын төрөл тус бүр дээр тодорхойлон, мөн энэхүү хүсэлтийнхээ тайлбар шалтгааныг тодорхой заасан хүсэлтээ багийн засаг даргад гаргана. Багийн засаг дарга нь энэхүү хүсэлтийг шалган үзээд, сумын ЗДТГ-т хүлээлгэн өгнө.

/Малын зээлийг буцаан төлөх/

11 зүйл. Малын зээл авах малчид нь малын төрөл тус бүрээр жилийн хүнсний хэрэглээнд зарцуулах болон борлуулах тоо толгой, буцаан төлөх тоо толгой зэргийг тодорхой заасан төлөвлөгөө боловсруулан, төслийн

хэрэгжилтийг хариуцах хүнээс зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Энэ төлөвлөгөөнд малын бойжилтыг 90%-тай байхаар, мал төлөлтийг хонинд 90 хувиар, ямаанд 85 хувьтай байхаар тооцоолон боловсруулах шаардлагатай.

12 зүйл. Малын зээлээр авсан хуцыг 2 жилийн хугацаанд буцаан төлнө.

/Малын зээлийг буцаан төлөх хугацаа/

13 зүйл. Санхүүжилтэнд хамрагдсан малчин нь малын зээлийг 2-с дээш ба 5 жилээс дотогш хугацаанд багтаан буцаан төлөх шаардлагатай.

/Малын зээлийг буцаан төлөх хугацааг сунгах, хойшлуулах/

14 зүйл. Төсөлд хамрагдсан малчин нь зээлээр авсан малаа буцаан төлөх хугацааны явцад байгалийн гамшиг зэрэг хүчин зүйлээс хамааран төлөвлөсөний дагуу малын зээлээ буцаан төлж чадахгүй болсон тохиолдолд, сумын засаг даргын зөвшөөрсөний үндсэн дээр зээлийн буцаан төлөлтийн шинэ хуваарь, төлөвлөгөөг боловсруулан баримтлах болно.

/«Малжуулах сангийн ашиглалтын журам»-д өөрчлөлт оруулах тухай/

15 зүйл. «Малжуулах сангийн ашиглалтын журам»-ийг мөрдөх явцад тус журмын агуулга, заалтыг өөрчлөх бодит шаардлага гарсан тохиолдолд, сангийн үйл ажиллагааг төлөөлөн удирдах сумын засаг дарга, төслийн хэрэгжилтийг хариуцах сумын ХАА-н түшмэл болон сангийн хөрөнгө мөнгөний асуудал хариуцах сумын төсөв санхүүгийн мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнээр хуралдан зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэр гаргаж, тус журмын агуулга заалтанд өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө. Харин өөрчлөлт оруулсан агуулга заалтын тухай багийн засаг даргаар дамжуулан малчдад шуурхай мэдэгдэх шаардлагатай.

Ноос боловсруулах жижиг үйлдвэрлэл байгуулах тухай гэрээний **САНАМЖ БИЧИГ**

Энэхүү санамж бичгийг "Монгол улсын Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөг боловсруулах судалгааны төсөл"-ийн хүрээнд малчдын бүлэг (бүлгийн ахлагч Р.Энхтуяа), сумын захиргаа болон ЖАЙКА төслийн Судалгааны багийн хооронд харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулсан болно.

Талууд тохиролцоонд хүрсэний дагуу доор дурьдсан үүргийг хүлээнэ.

(1) Малчдын бүлэг

- Бүлгийн үйл ажиллагаанд зориулан банкинд бүлгийн нэр дээр данс нээх, улмаар төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө үйл ажиллагааны эхний шатанд зайлшгүй гарах өртөг зардлыг санхүүжүүлэхэд бэлтгэх.
- Хавсралт 1-д дурьдсан машин тоног төхөөрөмжийг ажиллуулан бүлгийн хэвийн үйл ажиллагааг хангах. Машин, тоног төхөөрөмж эвдрэх, хулгайлагдах зэрэг шалтгааны улмаас үйлдвэрлэл зогссон тохиолдолд, цаашдын хэвийн үйл ажиллагааг хангах асуудлыг тухайн бүлэг хариуцах болно.
- Үйл ажиллагааны 2 дахь жилээс эхлэн хөрөнгө оруулалтын зардал болох 2,240,000 төгрөгийг Хавсралт 2 –д төлөвлөсөний дагуу "Улаан уул" сангийн дансанд 7 жилийн дотор 100% төлж барагдуулах.
- Бүлгийн үйл ажиллагааны тайланг ЖАЙКА Судалгааны баг болон Сумын захиргаанд тавих бөгөөд тэдгээрийн зүгээс тавих хяналт мониторингийн ажилд хамрагдах.

(2) Сумын захиргаа

- Малчдын бүлгээс "Улаан уул" санд төлөх хөрөнгө оруулалтын зардлын эргэн төлөлтөд Жайка Судалгааны багтай хамтран хяналт тавих,
- Бүлгийн үйл ажиллагааны явцад ямар нэгэн бэрхшээл тохиолдоход малчдын бүлэгт асуудлыг шийдвэрлэхэд нь бодит туслалцаа үзүүлэх.

(3) ЖАЙКА Судалгааны баг

- Малчдын бүлэг болон Сумын захиргааны зүгээс хэрэгжүүлэх үйл ажиллагааг хянах, чиглүүлэх.

Эрдэнэ сум,

2004 оны 6 сарын 3

Эрдэнэ сумын Засаг дарга

Р.Энхтуяа

Бүлгийн ахлагч

Такаши Фүжита

"ЖАЙКА" Судалгааны багийн ахлагч

Сүүн бүтээгдэхүүн борлуулах төсөл Гэрээ

1. Малчдын бүлэг (төлөөлөгч: _____) нь Монгол улсад зудтай тэмцэхэд чиглэгдсэн орон нутгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төслөөр хэрэгжих сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах төслийг үйл ажиллагааны төлөвлөгөө (Боловсруулсан 2005 он 5 сарын 30-ний өдөр)-нд үндэслэн, бүлгийн гишүүд хамтран хэрэгжүүлэхээр тохиролцлоо.
2. Дээрх төсөлд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг судалгааны багаас Эрдэнэ сумын ЗДТГ (төлөөлөгч: _____)-т олгож, сумын ЗДТГ нь тэдгээр тоног төхөөрөмжүүдийг малчдын бүлэгт төлбөртэйгөөр зээлээр олгоно.
3. Малчид, дээр заасан бүх тоног төхөөрөмжийн засвар арчлалтыг хариуцах ба хулгай болон анхаарал болгоомжгүйгээс үүдэх эвдрэл гэмтэлд сумын ЗДТГ буюу судалгааны баг аливаа хариуцлага хүлээхгүй.
4. Малчдын бүлэг үйл ажиллагааны тэмдэглэл хөтөлж, сумын ЗДТГ буюу судалгааны багийн хэрэгжүүлэх мониторингийн ажиллагаанд хамтран ажиллах үүрэг хүлээнэ.
5. Сумын ЗДТГ нь малчдын бүлгийн үйл ажиллагаанд тусалж, малчдын бүлэг дангаараа шийдэхэд хүндрэлтэй асуудлууд дээр тодорхой зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.
6. Судалгааны баг, Монгол улсад зудтай тэмцэхэд чиглэгдсэн орон нутгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулахад туслах төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд малчдын бүлэг болон сумын ЗДТГ-ын аль алины үйл ажиллагаанд хяналт тавьж байна.
7. Малчдын бүлэг, хавсралтад заасан тоног төхөөрөмжийн худалдан авсан үнэ ба тээвэрлэлтийн зардлыг 3 жилийн хугацаанд сумын фондод бүрэн хэмжээгээр эргүүлэн төлнө.
8. Дээрх тоног төхөөрөмжийн худалдан авсан үнэ ба тээвэрлэлтийн зардал сумын фондод бүрэн хэмжээгээр эргэн төлөгдсөнөөр сумын ЗДТГ, сүүн бүтээгдэхүүн борлуулах төсөл хэрэгжүүлэх сонирхолтой бусад малчдын бүлгээс хүсэлт тавьсан тохиолдолд тэдний үйл ажиллагааны төлөвлөгөөг түргэн хугацаанд бүрэн судалж, уг бүлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч зээлээр олгож байна.
9. Малчдын бүлэг, сумын ЗДТГ, судалгааны баг 3 талаас тохиролцон, сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах төслийн талаарх энэхүү гэрээг байгууллаа.

Дорноговь аймгийн _____ сум
2005 он сарөдөр.

Дорноговь аймгийн Эрдэнэ сум
багийн харьяат, малчдын бүлгийн ахлагч

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын
Засаг дарга

Гэрчилсэн:

